



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/217

Улаанбаатар хот

Түр тариф батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн 11.1.20 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1 дэх заалт, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоол, Зам, тээврийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дугаар тушаалын аравдугаар хавсралтаар батлагдсан “Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлал”, Зам, тээврийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Аюултай ачаа тээвэрлэлтийн талаар авах арга хэмжээний тухай” А/152 дугаар тушаал, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замд мөрдөх “Тарифын 1-р мөрдлөг”-ийг нэгдүгээр хавсралтаар, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замд мөрдөх “Суурь бүтэц ашиглалтын тариф”-ыг хоёрдугаар хавсралтаар, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд “Экспортын нүүрс төмөр замаар тээвэрлэх үйлчилгээний 1 тонн ачааны багцын тариф”-ыг гуравдугаар хавсралтаар, “Тарифын 2-р мөрдлөг”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2022 оны А/28 дугаар тушаалын Ажил үйлчилгээний хөлс хүснэгтийн 17 дахь заалт “Эзэмшлийн вагоноор хангасны хөлс”, 2025 оны А/83, А/114, А/299 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалыг 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4.Тушаалыг хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тээврийн удирдлагын газар (Г.Шижирбаатар)-т, Санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т, Хууль эрх зүй, хамтын ажиллагааны газар (С.Түвшинжаргал)-т тус тус даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Ц.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.БАТЧУЛУУН

1426011271

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 04 дүгээр сарын 30 ны өдрийн
А/217 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт



ТАРИФЫН НЭГДҮГЭЭР МӨРДЛӨГ

Нэр томьёо

Энэхүү тарифын мөрдлөгт хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

- **МТЗ ТӨХК** гэж “Монголын төмөр зам” ТӨХК-ийг ойлгоно.
- **Вагон илгээлт** гэж нэг тээврийн бичиг баримт /падаан/-аар илгээж байгаа ачааг;
- **Чингэлэг илгээлт** гэж тээвэрлэлтэд тусдаа чингэлэг шаардагдах тээврийн нэг тээврийн бичиг баримт /падаан/-аар илгээж байгаа ачааг;
- **Суурь бүтэц ашиглуулах тариф** гэж суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэгчийн өмчийн хэлбэрээс үл хамааран гэрээний үндсэн дээр суурь бүтэц ашиглуулсан тохиолдолд авах төлбөр хураамжийг хэлнэ.
- **Тээврийн хөлс /тариф/** гэж тээвэрлэгч нь хууль, тогтоомжийн дагуу нийтэд зарласан, ачаа тээвэрлэх гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгч байгууллага, иргэдээс авах төлбөр хураамжийг хэлнэ.
- **Ачилт буулгалтын тариф** гэж нийтийн болон дагнасан хэрэглээний төмөр замд төмөр замын хүч, хэрэгслээр ачилт, буулгалтын ажиллагаа гүйцэтгэсэн тохиолдолд авах хураамжийг хэлнэ.
- **Ажил үйлчилгээний хураамж** гэж төмөр замын ачаа тээвэрлэлттэй холбоотой сэлгээний ажил гүйцэтгэх, зам, вагоноо ашиглуулах, ачааны жин тодорхойлох, ачаа /чингэлэг/ хадгалах, бичиг баримт бүрдүүлэх, ачааг хамгаалах, вагон /чингэлэг/ цэвэрлэх, ачааны бэхэлгээ хийх, вагон /чингэлэг/ ломбодох гэх мэт нэмэлт ажил үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой төлбөр хураамжийг хэлнэ.
- **Тарифын зай** гэж ачааны тээврийн хөлсийг бодож тооцох тээвэрлэлтийн зайг хэлнэ. Уг зайг гол замын тоолж эхлэх цэг /0,00 км/-ээс гол замын төгсгөлийн цэг хүртэл тооцно.
- **Сэлгээний ажил гүйцэтгэх зай** гэж Өртөө, зөрлөгийн тэнхлэгээс ачилт, буулгалтын ажил гүйцэтгэх нийтийн болон дагнасан хэрэглээний замын төгсгөлийн цэг хүртэлх зайг хэлнэ.
- **Гол километр** гэж нэг километр зайд гүйх вагоны нэг голын гүйлтийг харуулсан ашиглалтын үзүүлэлтийг;
- **Дагнасан хэрэглээний зам** гэж эзэмшигчийн өөрийн хэрэгцээг хангах буюу гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэхэд зориулагдсан салбар замыг;
- **Нийтийн хэрэглээний зам** гэж төмөр замын шугам, өртөөнд галт тэрэг хүлээж авах, явуулах, ялгах болон сэлгээний ажил гүйцэтгэх, ачаа, ачааны тээш хүлээн авах, олгох, зорчигчдод үйлчлэх зам, түүнчлэн нийтэд үйлчлэх зориулалттай бусад салбар замыг;
- **Өртөөний дотоод тээвэрлэлт** гэж илгээгч, хүлээн авагчийн өөрийн хүсэлтээр өртөөний нэг салбар замаас “Монголын төмөр зам” ТӨХК-ийн өртөөгөөр дамжин нөгөө салбар зам хүртэл тарифын нэг бүсэд ачаа тээвэрлэлт хийхийг;
- **Тээвэрлэгчид үл харьяалагдах вагон /чингэлэг/** гэж хуулийн этгээд эсвэл хувь хүнд харьяалагдах өөрийн дугаартай вагон /чингэлэг/ болон түрээсэлсэн вагон (чингэлэг)-ыг хэлнэ.
- **Тээврийн бичиг баримт** гэж тээврийн гэрээ байгуулсныг батлах бичиг баримтыг (төмөр замын тээврийн падаан);
- **Түгээмэл зориулалтын чингэлэг** гэж Олон улсын стандарт эсвэл ачаа илгээгч орны стандартаар зөвшөөрөгдөж энэ тухай тээврийн бичиг баримтад /падаан/-д “Чингэлэг” гэж тэмдэглэгдсэн чингэлгийг;
- **Дээвэргүй чингэлэг** гэж нүүрс болон бусад ачаа тээвэрт хэрэглэгдэж байгаа тусгай зориулалтын чингэлэг /open top/-ийг хэлнэ.

- **Урт ачаа** гэж ачааны уртыг хөдлөх бүрэлдэхүүний баазад харьцуулахад 1,41-ээс илүү гарч байгаа ачааг;
- **Хүнд жинтэй ачаа** гэж ачааны жин, вагоны шаланд өгөх ачаалал нь вагоны техникийн нөхцөлийн дагуу тогтоосон хэмжээнээс хэтэрсэн ачааг;
- **Аюултай ачаа** гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд аюултай, хортой нөлөөлөл үзүүлэх, улмаар үхэл мөхөлд хүргэх үйлчилгээтэй, төмөр замаар тээвэрлэх, ачилт, буулгалт хийх болон хадгалалтын үед төмөр замын төхөөрөмж, хөдлөх бүрэлдэхүүн болон бусад ачааг гэмтээх тэсэрч дэлбэрэх, шатамхай, хялбар шатах ачааг;
- **Сэргээн босголт** гэж төмөр замд гарсан осол сүйрлийн үед газар дээр нь яаралтай сэргээн босгох, хөдлөх бүрэлдэхүүн замаас гарах, хөдлөх бүрэлдэхүүн зам, замын байгууламжийн эвдрэл гэмтлийг богино хугацаанд засах зорилготой үйл ажиллагааг;
- **Овор** гэж хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүйн техникийн шаардлагын дагуу төмөр замын объект, хөдлөх бүрэлдэхүүн, төмөр замын ойролцоох барилга байгууламж, ачааны байршлын зайн хязгаарыг тогтоосон хэмжээг;
- **Хэтрүү овортой ачаа** гэж тэгш шулуун зам дээр зогсож байгаа задгай хөдлөх бүрэлдэхүүний тууш тэнхлэг замын тууш тэнхлэгтэй нэг босоо хавтгайд давхцаж байхад уул хөдлөх бүрэлдэхүүн дээр ачаа ачсан нь төмөр замын ачилтын оврын хязгаарын хүрээнээс гадагш илүү гарч байгаа ачааг;
- **Ачаа хамгаалагч** гэж хоорондын замд ачаа, вагоныг хянаж, хамгаалах үүрэгтэй тээвэрлэгчийн эрх бүхий хамгаалалтын байгууллагын ажилтныг хэлнэ;
- **Хяналтын жааз** гэж хэтрүү овортой ачааны загварыг давтсан, вагон дээр зориуд байрлуулсан хялбар модон хийцийг;
- **Хаяг солилт** гэж илгээгч, хүлээн авагчийн бичсэн хүсэлтээр зохих зөвшөөрлийн дагуу хүрэх өртөө, хүлээн авагчийн хаягийг солихыг;
- **Бичиг баримтад хийх засвар** гэж үйлчлүүлэгч /илгээгч/-ийн хүсэлтийг үндэслэн хүрэх өртөө, хүлээн авагчаас бусад өөрчлөлт засварыг;

1 ҮНДСЭН МЭДЭГДЭХҮҮН

1.1. Энэхүү тарифын мөрдлөгийг вагон, чингэлгийг их, бага хурдаар тээвэрлэсний болон нэмэгдэл ажил үйлчилгээ үзүүлсний төлбөр хураамжийг бодож авахад хэрэглэнэ.

Тээврийн тарифыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Вагон илгээлт,
- Чингэлэг илгээлт,
- Тээвэрлэгчид үл харьяалагдах вагон /чингэлэг/-оор ачаа тээвэрлэх,
- Хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн гол дээр нь тээвэрлэх,

1.2. Орон нутгийн харилцаанд тээвэрлэж байгаа ачааны тээврийн төлбөр хураамжийг “МТЗ” ТӨХК-ийн илгээх өртөөнөөс “МТЗ” ТӨХК-ийн хүрэх өртөө хүртэл, Олон Улсын төмөр замын харилцаанд тээвэрлэж байгаа ачааны тээврийн төлбөр хураамжийг Монгол Улсын хилээс “МТЗ” ТӨХК-ийн хүрэх өртөө, “МТЗ” ТӨХК-ийн илгээх өртөөнөөс Улсын хил хүртэлх зайд бодно.

1.3. Ачаа тээвэрлэсний төлбөр хураамж бодохдоо ачааны бүлэг, тээвэрлэлтийн зайнаас хамааруулан вагон илгээлт, чингэлэг илгээлт тутмаас, хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн гол тутмаас, тээвэрлэгчид үл харьяалагдах вагон, чингэлэг тутмаас тус тус бодож тооцно.

1.4. Олон Улсын шууд бус харилцааны ачаа тээврийн зарим үйлчилгээний хураамжийг бодохдоо ачаа илгээсэн өртөө буюу хилийн орох өртөөний хуанлийн тэмдгийг тээврийн бичиг баримт /падаан/, замын хүснэгт дээр дарсан тухайн өдөр мөрдөгдөж байсан тарифаар тооцно. Нэмэгдэл үйлчилгээний хөлсийг бодохдоо эдгээрийг ногдуулан хураах тухайн өдрийн мөрдөж байгаа үнэлгээг баримтална.

1.5. Энэхүү тариф, төлбөр, хураамжийн дүнд НӨАТ багтсан болно.

2 ТАРИФЫН ЗАЙ

2.1. “МТЗ” ТӨХК-ийн өртөө, зөрлөгүүдийн хоорондын зайг “Тарифын 2-р мөрдлөг”-өөр тодорхойлно.

2.2. Бусдын суурь бүтцээр тээвэрлэлт хийх үеийн тарифын зайг тухайн суурь бүтэц эзэмшигчийн тодорхойлсон зайгаар тооцно.

2.3 Олон Улсын шууд бус харилцаанд тээвэрлэж буй ачааны тарифын зайг илгээх/хүрэх өртөөнөөс хилийн өртөө хүртэлх зайгаар тодорхойлно.

2.4. Ачааны ажиллагаанд нээлттэй нэг өртөөнөөс нөгөө өртөө хүртэл ачааг тээвэрлэлтэд хүлээн авна.

2.5. Ачааны ажиллагаанд хаалттай зөрлөг рүү тээвэрлэлт хийх тохиолдолд Тээврийн асуудал хариуцсан эрх бүхий ажилтнаас зөвшөөрөл авсан байна.

2.5.1. Тээвэрлэх ачааны хүрэх өртөө нь ачааны ажиллагаанд хаалттай тохиолдолд ачаа илгээгч нь ачааны ажиллагаанд нээлттэй ойролцоо өртөөг хүрэх гэж падаанд зааж эцсийн цэгийн тухай нэмэлт тэмдэглэлийг хүрэх өртөөний нэрийн ард хаалтад зааж бичнэ.

а. Ачааны ажиллагаанд хаалттай өртөөний замд мөн ачааны ажиллагаанд нээлттэй боловч тооцооны хэсэггүй өртөөний замд ачилт, буулгалт хийх тохиолдолд тээвэрлэлтийн зайг ойролцоох ачааны ажиллагаанд нээлттэй өртөөгөөр тооцно. Энэ тохиолдолд тавилт, таталтын зайг ачааны ажиллагаанд нээлттэй өртөөнөөс хаалттай өртөө хүртэлх зай ба хаалттай өртөөний гол замаас салбар зам хүртэлх зайн нийлбэрээр тооцно. Тээврийн хөлсний тооцоог ойролцоох ачааны ажиллагаанд нээлттэй өртөөний тооцооны хэсэгт хийнэ.

б. Ачааны ажиллагаанд нээлттэй өртөөнөөс ачааны ажиллагаанд хаалттай өртөө, зөрлөг рүү шууд тээвэрлэлт хийсэн тохиолдолд тээвэрлэлтийн зайг хүрэх өртөөгөөр тооцно. Энэ тохиолдолд тавилт таталтын зайг хаалттай өртөөний гол замаас салбар зам хүртэлх зайгаар тооцно.

2.6. Тээвэрлэлтийн хамгийн бага зай нь 30 км хүрэхгүй байвал 30 км-ээр тооцно. Гол-км-ээр тооцдог тээврийн хөлсийг бодоход энэ заалт хамаарахгүй жинхэнэ явсан зайгаар тооцно.

2.5. Тээвэрлэлтийн хамгийн бага зай нь 30 км хүрэхгүй байвал 30 км-ээр тооцно. Гол-км-ээр тооцдог тээврийн хөлсийг бодоход энэ заалт хамаарахгүй жинхэнэ явсан зайгаар тооцно.

3 АЧААНЫ НЭР

3.1. Ачаа илгээгч нь ачааны нэрийг тодорхойлсон уялдуулсан систем (ГНГ)-д заагдсан ачааны нэрстэй тохируулан ачаагаа нэрлэж, кодыг тээврийн бичиг баримт /падаан/-д бичнэ.

3.2. Ачааны нэр дутуу буюу тодорхой бус байвал ачаа илгээх өртөөнд ачааны нэрийг илгээгч тодотгоно. Ачааны нэрийг тодруулж өгөх хүртэл уг ачааг тээвэрлэлтэд хүлээн авахгүй байж болно.

3.3. Ачааны нэр тодорхой бус байгаа нь хүрэх өртөөн дээр илэрсэн тохиолдолд энэ тухай “Ерөнхий маягтын акт” тогтоож, тээврийн бичиг баримтад хавсаргана.

4 АЧААНЫ ЖИН, ТҮҮНИЙГ БҮХЭЛЧЛЭХ

4.1. Тээврийн болон ачилт, буулгалтын хураамжийг бодохын тулд ачааны жинг дараах байдлаар бүхэлчилнэ: Үүнд:

а/ Нэг бүлэгт хамааруулсан хэд хэдэн төрлийн ачааг нэг төрлийн ачаа гэж тэдний нийт жинг бүхэл тоонд дэвшүүлэн тооцно.

б/ Ачааны баглаа боодол, ачмаг /тавиур/ болон бусад хэрэгслийг ачааны нийт жинд оруулж тооцно.

5 АЧААНЫ ТЭЭВРИЙН ХӨЛС БОДОХ ЖУРАМ

5.1 ЕРӨНХИЙ ЗААЛТ

5.1.1. Бага хурдаар тээвэрлэх ачааны тээврийн тарифыг 1-12 дугаар бүлгийн ачааг тээвэрлэх үед тооцохоор тодорхойлов.

5.1.2. Их хурдаар тээвэрлэх ачааны тээврийн тарифыг тооцохдоо дээрх бүлэгт заасан үнэлгээг 50%-иар нэмэгдүүлэн тооцно.

5.1.3. Нэг бүлэгт хамаарахгүй 3 ба түүнээс дээш нэр төрлийн ачааг нэг вагонд ачсан ачааны тээврийн тарифыг бодохдоо 11-р бүлэг буюу холимог ачааны бүлгээр тооцно.

5.1.4. Нэг вагонд ачсан хоёр өөр бүлгийн ачааны тээврийн тарифыг бодохдоо өндөр үнэлгээтэй ачааны бүлгээр нийт тээврийн зайд тооцно.

5.1.5. Төлбөр хураамж тооцож бодохдоо 100 төгрөг хүрэхгүйг 100 төгрөгөөр бүхэлчлэн тооцно.

5.2 ЧИНГЭЛЭГ ИЛГЭЭЛТИЙН ТЭЭВРИЙН ТАРИФ БОДОХ

5.2.1. Их даацын чингэлэг илгээлтийн тээврийн тарифыг орон нутгийн харилцааны ачаа тээврийн тарифын 12 дугаар бүлэг буюу “Чингэлэг тээврийн тариф”-ийн дагуу тооцно.

5.2.2. Тээвэрлэгчид үл харьяалагдах чингэлгийг хоосноор тээвэрлэхэд, үйлчлүүлэгч байгууллагын захиалга /эсвэл гэрээний үндсэн дээр/ тээврийн бичиг баримт үйлдэж, тарифын 12 дугаар бүлэг буюу “чингэлэг тээврийн тариф”-ийн дагуу тооцно.

5.2.3. “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн чингэлгийг хоосноор тээвэрлэхэд тээврийн бичиг баримт үйлдэх бөгөөд тээврийн төлбөр хураамж тооцохгүй.

5.2.4. Их даацын 40 футээс дээш ангиллын чингэлэг тээврийн тарифыг тооцохдоо 12 дугаар бүлгийн 40 футийн чингэлгийн тарифыг 1.2 өсгөх коэффициентоор нэмэгдүүлж тооцно.

5.2.5. Чингэлэгт ачаа ачихдаа түүний даац, багтаамжийг хэтрүүлэхгүй ачаалсан байна.

5.3 ВАГОН ИЛГЭЭЛТИЙН ТЭЭВРИЙН ТАРИФ БОДОХ

5.3.1. Вагон илгээлтийн тээврийн тарифыг тээврийн бичиг баримт /падаан/-д заасан ачааны нэр, тээвэрлэлтийн зайг үндэслэн орон нутгийн харилцааны ачаа тээвэрлэлтийн тарифын дагуу тооцно.

5.3.2. Вагоны нэг голоос зам төмөрт ирэх ачаалал нь 25 тонноос хэтэрч болохгүй. Мөн ачааны жин нь вагоны техникийн паспортод заасан дээд даацаас хэтэрч болохгүй.

5.3.3. Ачааг аль нэг өртөөн дээр шилжүүлэн ачих тохиолдолд вагоны төрөл, даац, багтаамжаас шалтгаалан ачаа нь нэг вагонд багтахгүй бол үндсэн ачааг өөр вагонд ачиж нөхөн илгээлтийн бичиг баримт үйлдэж үндсэн илгээлтийн хамт хүрэх өртөө рүү илгээнэ. Энэ тохиолдолд өөр вагонд ачсан ачааны тээврийн тарифыг түүний жингээс хамааруулан дараах бууруулах коэффициентоор үржүүлэн тооцно. Үүнд:

- 10 тонн хүртэл ачсан тохиолдолд 0.3 коэффициентоор.
- 11-ээс 20 тонн хүртэл ачсан тохиолдолд 0.5 коэффициентоор.
- 21 тонноос дээш ачсан тохиолдолд ачааны тээврийн тарифыг вагон илгээлтийн бүтэн тарифаар тус тус тооцно.

5.3.4 “Монголын төмөр зам” ТӨХК-ийн аж ахуйн ачааг тээвэрлэхэд Тээврийн асуудал хариуцсан нэгжийн даргын зөвшөөрлөөр тээврийн бичиг баримт үйлдэх бөгөөд тээврийн хөлс, нэмэлт хураамж тооцохгүй.

5.3.4.а. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн аж ахуйн ачаа нь компанийн өөрийн үйл ажиллагаанд ашиглагдах ачаа байх бөгөөд тээвэрлэсний дараа гадны байгууллага, хувь хүмүүст худалдах дамжуулах арилжааны зориулалтгүй байх ёстой. Ачаа илгээгч болон хүлээн авагч нь “МТЗ” ТӨХК-ийн аж ахуй нэгж байна.

5.3.4.б. Тээврийн бичиг баримтад ачааны нэр хүснэгтэд “Аж ахуйн ачаа” гэж зааж, тухайн ачааны нэрийг хаалтад бичнэ.

5.3.5. Нэг илгээгч, нэг хүлээн авагчтай (нэг бүлгийн) хэд хэдэн вагоноос илүү гарсан ачаануудыг нэгтгэн, нэг нөхөн илгээлтээр явуулах тохиолдолд тээврийн тарифыг нөхөн илгээлтээр явуулж буй ачааны жинхэнэ жингээр 5.3.3-д заасан коэффициентоор тооцно.

5.4 ХҮНД ЖИНТЭЙ, УРТ ХЭМЖЭЭТЭЙ, ХЭТРҮҮ ОВОРТОЙ, АЮУЛТАЙ АЧААНЫ ТЭЭВРИЙН ХӨЛС БОДОХ

5.4.1. Нэг тээврийн бичиг баримт /падаан/-аар хүнд жинтэй, урт хэмжээтэй, хэтрүү овортой ачааг хэд хэдэн вагонд тээвэрлэсэн тохиолдолд тээврийн тарифыг вагон тутмаар тооцож бодно.

5.4.2. а/ Хэтрүү овортой болон урт ачааны тээврийн тарифыг бодохдоо тухайн ачааны бүлгийн тарифыг 100%-иар нэмэгдүүлэн тооцно. Илгээх өртөө тээврийн бичиг баримтад оврын тухай тэмдэглэгээг хийсэн байх ёстой. Халхавч болгож ашигласан буюу овор

шалгах жааз хадсан вагоны тээврийн тарифыг тухайн тээвэрлэж байгаа ачааны бүлгийн тарифаар тооцно.

б/ Аюултай ачааны тээврийн хөлсийг тооцохдоо тухайн ачааны бүлгийн тарифыг 100% нэмэгдүүлэн тооцно. Аюултай ачаанд “МТЗ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын баталсан аюултай ачааны жагсаалтад багтсан бүх ачаа хамаарна.

5.4.3. Урт ачааг тээвэрлэх үед халхавч болгон ашиглаж байгаа тавцант вагоны даац багтаамжийг ашиглан өөр төрлийн ачаа ачсан бол тухайн ачааны бүлгийн дагуу тээвэрлэлтийн тарифыг тооцож, 5.4.2-ын “а” заалтыг мөрдөхгүй.

5.4.4. Хүнд даацын ачаа тээвэрлэх тусгай зориулалтын вагон /транспортёр/-оор ачаа тээвэрлэсэн тохиолдолд илгээх өртөө нь тээврийн тарифаас гадна транспортёр вагоныг захиалж ирүүлсэн болон ачилтын өртөө хүртэлх хоосон гүйлтийн хураамжийг тооцно.

5.5 ӨРТӨӨНИЙ ДОТООД ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТАРИФ БОДОХ

5.5.1. Өртөөний дотоод тээвэрлэлтэд тээврийн бүрэн бичиг баримт бүрдүүлэх ба замын хүснэгт, замын хүснэгтийн хуулбарын дээд хэсэгт “Өртөөний дотоод тээвэрлэлт ” гэсэн тэмдэглэлийг хийнэ.

5.5.2. Өртөөний дотоод тээвэрлэлтийн тээврийн тарифыг тухайн ачсан ачааны тээврийн тарифаар тооцох ба тээвэрлэлтийн хамгийн бага зай 30 км хүрэхгүй бол 30 км-р тооцно.

5.6 АЧААГ ХҮРГЭГЧТЭЙГЭЭР ТЭЭВЭРЛЭСНИЙ ТАРИФ БОДОХ

5.6.1. Ачаа илгээгч, хүлээн авагчийн хүргэгч дагалдсан вагон илгээлтийн тээврийн тарифыг вагон тутмаас тарифын дагуу бодож хураана.

5.6.2. Ачаа хүргэгчийн амь даатгалын хураамжийг даатгалын компанитай байгуулсан гэрээнд заасан тарифын дагуу тооцож авна.

5.6.3. Ачаа илгээгчийн хүсэлтээр “МТЗ” ТӨХК-ийн харуул хамгаалалттай /хамгаалагчтай/ болон ачаа хүргэгч нь ачаагаа дагалдан ачааны вагонд зорчсон төлбөрийг ачсан ачааны бүлгийн тарифын 10 хувиар тооцон хамгаалсан болон ачаа дагалдсан вагон тус бүрээс илгээгчээс авна.

5.7 ХАЯГ СОЛИЛТЫН ТАРИФЫГ БОДОХ

Тээвэрлэлтэд хүлээн авсан эсвэл замд яваа ачааны хаяг солих тохиолдолд түүний тээврийн төлбөр хураамжийг:

а/ тээвэрлэлтэд хүлээн авсан ачаа илгээх өртөөнөөс хөдлөөгүй үед өртөөн дээр хаяг солих хүсэлт гаргасан ачаа илгээгчээс;

б/ илгээх өртөөнөөс хөдөлснөөс хойш болон хилийн орох өртөөнд хаяг сольсон тохиолдолд хүрэх өртөөнд хүлээн авагчаас тус тус тооцож авна.

5.8 ТЭЭВЭРЛЭГЧИД ҮЛ ХАРЬАЛАГДАХ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНЭЭР / ЗҮТГҮҮР, ВАГОН/ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ҮЕИЙН ТАРИФ БОДОХ

5.8.1. Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоноор ачаа тээвэрлэх үед орон нутгийн вагон, чингэлэг илгээлтийн тээврийн тарифын дүнгээс 15 хувь хөнгөлнө.

5.8.2. Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоныг төмөр замын нийтийн хэрэгцээний болон төмөр замын байгууллагын эзэмшлийн зам дээр ачилт, буулгалтын ажиллагаа /хоёрчилсон ажиллагаанд орох/ хийгдэх буюу ачаатай ба хоосноор зогсоох тохиолдолд зам ашигласны төлбөр хураамжийн санамжийг үндэслэн 1-3 хоногт вагон бүрээс хоног тутамд 20000 төгрөг, 4-с дээш хоногт вагон бүрээс хоног тутамд 100000 төгрөгөөр, Газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлүүлэгч нараас 1-3 хоногт вагон бүрээс хоног тутамд 20000 төгрөг, 4-7 хоногт вагон

бүрээс хоног тутамд 40000 төгрөг, 8 ба түүнээс дээш хоногт вагон бүрээс хоног тутамд 80000 төгрөгөөр тооцон авна.

5.8.3. Тээвэрлэгчид үл харьяалагдах зүтгүүрийг төмөр замын нийтийн хэрэгцээний болон төмөр замын байгууллагын эзэмшлийн зам дээр зогсоовол санамжийг үндэслэн 1-3 хоногт зүтгүүр бүрээс хоног тутамд 20000 төгрөг, 4-7 хоногт зүтгүүр бүрээс хоног тутамд 40000 төгрөг, 8 ба түүнээс дээш хоногт зүтгүүр бүрээс хоног тутамд 80000 төгрөгөөр зам ашиглалтын хөлсийг тооцон авна.

5.8.4. Засвар үйлчилгээ хийх гэрээнд дурдагдсан зүтгүүр, вагоныг засварын замд зогсож үйлчилгээ хийлгэсэн хугацаа энэхүү заалтанд хамаарахгүй

5.8.5. "МТЗ" ТӨХК-ийн үйл ажиллагаанаас шалтгаалсан сул зогсолтын хугацааг ерөнхий маягтын актаар тодорхойлон хасаж тооцно.

6 АЧИЛТ, БУУЛГАЛТ, ШИЛЖҮҮЛЭН АЧИЛТЫН ТӨЛБӨР ХУРААМЖ БОДОХ

6.1 "МТЗ" ТӨХК-аар тээвэрлүүлэхээр захиалга өгсөн ачааг нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шилжүүлэн ачих үед энэхүү тарифыг хэрэглэнэ.

6.2 Ачааны хувьд:

Д/д	Ажиллагааны төрөл	Хэмжих нэгж	Үнэлгээ /төг/		Тайлбар
			Ачих	Буулгах	
1	Бүх төрлийн ачааг гар аргаар ачих, буулгах	1 тонн	9000	9000	
2	Бүх төрлийн ачааг бага оврын механизм /сэрээт авто ачигч гэх мэт/ ашиглан ачих, буулгах	1 тонн	7500	7500	
3	Нунтаг нурмаг ачааг механизм /ковш гэх мэт/ ашиглан ачих, буулгах	1 тонн	8000	8000	
4	Хүнд даацын чингэлэг ачигч ашиглан ачих, буулгах	1 тонн	10000	10000	Чингэлгээс бусад төрлийн ачааг ган болон уян тэнжээ ашиглах ачих буулгах үед ашиглана.
5	Цахилгаан болон авто кран /өргүүр/-аар ачих, буулгах	1 тонн	10000	10000	
6	Шингэн юүлмэг ачаа ачих, буулгах	1 тонн	9000	9000	
7	Тусгай зориулалтын өндөрлөсөн зам, тавцан, төхөөрөмж ашиглан машин, техник ачих, буулгах	1 вагон	300000	300000	Машин механизмыг өөрийн явах ангиар вагонд ачих, буулгах үед ашиглана.

6.3 Чингэлгийн хувьд:

Д/д	Чингэлгийн төрөл	Шилжүүлэн ачилтын хөлс, (төг/чингэлэг)	
		ачаатай	хоосон
1	20 фут ба түүнээс дээш 30 фут хүртэлх	75000	37500
2	30 фут ба түүнээс дээш 40 фут хүртэлх	100000	50000
3	40 фут ба түүнээс дээш чингэлэгт	112500	56300
4	Дээвэргүй чингэлэг /20 фут/	70000	35000

6.4 Ачаа илгээгч /хүлээн авагч/-ийн хүч хэрэгслээр ачилт, буулгалтын ажиллагааг гүйцэтгэсэн тохиолдолд тээврийн бичиг баримт /падаан/-д “Илгээгчийн хүчээр ачсан”, эсвэл “Хүлээн авагчийн хүчээр буулгасан” гэсэн тэмдэглэл хийнэ. Энэ тохиолдолд 6.1, 6.2, 6.3 дахь заалтууд хамаарахгүй.

6.5 Чингэлгийн шилжүүлэн ачилтын үед нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шууд шилжүүлэн ачаагүй талбайд буулгаад дахин ачих тохиолдолд тухайн чингэлгийн шилжүүлэн ачилтын тарифыг 20 хувиар нэмэгдүүлэн тооцно.

7 ВАГОН ТАВЬЖ ӨГӨХ, ТАТАН АВАХ БОЛОН СЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ БОДОХ

7.1.Төмөр замын харьяа байгууллагын болон ачаа илгээгч, хүлээн авагчийн эзэмшлийн салбар замд вагоныг тавьж өгөх, татаж авах болон сэлгээний ажлыг “Салбар замыг ашиглах, вагон тавьж өгөх, татаж авах гэрээ”-ний үндсэн дээр гүйцэтгэнэ.

7.2.Нийтийн болон дагнасан хэрэглээний замд ачилт, буулгалтын ажиллагаанд вагон тавьж өгөх, татаж авах болон сэлгээний ажил гүйцэтгэсэн үед дараах байдлаар тооцно.

а. Ачилт, буулгалтын ажиллагаанд вагон тавьж өгөх, татаж авах түүнчлэн вагон тавьж өгсний дараа буюу татаж авахаар зүтгүүрийг хоосон явуулсан хөлсийг зүтгүүр-км тутамд 10,000 төгрөгөөр;

б. Хоорондын замд дээрх ажиллагааг гүйцэтгэх тохиолдолд тээврийн асуудал хариуцсан нэгжийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Тухайн зам дээр сэлгээний ажил гүйцэтгэвэл ажилласан хугацаагаар сэлгээний хөлсийг тооцож авна.

7.3 Вагон тавьж өгч, татаж авсан хөлсийг зүтгүүр-км-ээр хоёр талдаа явсан жинхэнэ зайгаар тооцно. Салбар замд сэлгээний ажил гүйцэтгэсэн тохиолдолд 30 минут нь 75000 төгрөг байна. 30 минут хүрэхгүй хугацааг 30 минут гэж тооцно. Сэлгээ хийсэн цагийг санамжид Ачаа вагон хүлээлцэгч /ABX/ бичиж тооцооны хэсэгт тушаана.

7.4 Төмөр замын нийтийн хэрэглээний зам /нийтэд үйлчлэх зориулалттай салбар зам буюу шилжүүлэн ачих терминал/-д тавьж өгөх, татаж авах ажиллагааны төлбөрийг вагон илгээлт тутмаас 6000 төгрөг, чингэлэг илгээлт бол 40 фут болон түүнээс дээш чингэлэг тутмаас 4500 төгрөг, 30 фут ба түүнээс дээш 40 фут хүртэлх чингэлэг тутмаас 4000 төгрөг, 20 фут-ээс 30 фут хүртэлх чингэлэг тутмаас 3000 төгрөг тус тус тооцно

8. ВАГОН АШИГЛАЛТЫН ТӨЛБӨР ХУРААМЖ БОДОХ

8.1.“МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн ачилт /буулгалт/-ын замд тавьж өгснөөс ачилт, буулгалтын ажиллагаа бүрэн дуусаж, түүнтэй холбоотой төлбөр тооцоо хийгдэж дуусах хүртэл хугацаанд тухайн вагоныг зогсоосон хугацаагаар санамжийг үндэслэн ачаа илгээгч /хүлээн авагч/-ээс доорх тарифаар вагоны төрлийг харгалзахгүйгээр вагон-цаг тутмаас;

1 хоног дотор

2500 төгрөг,

2-4 хоногт	3500 төгрөг,
5-7 хоногт	4500 төгрөг,
8-с дээш хоногт	6500 төгрөг.

Гадаад улсын төмөр замын эзэмшлийн вагон ашиглалтын хөлсийг тооцохдоо вагоны төрөл харгалзахгүйгээр вагон-цаг тутмаас:

1-15 хоногт	3800 төгрөг,
16-с дээш хоногт	4400 төгрөг,

Вагон ашиглалтын төлбөр хураамжийг санамжийг үндэслэн тооцох ба цаг хүрэхгүй хугацааг бүтэн цагт тооцно.

8.2 Тээвэрлэгчээс шалтгаалан үйлчлүүлэгчдэд цаг хугацаанд нь вагоныг ачилт, буулгалтын замд тавьж өгч татаж авч чадаагүй /байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан болон зүтгүүрийн хүчин чадал болон хүрэлцээгүй, тээвэрлэгчийн буруутай байдлаас үүсэн гарсан нөхцөлүүдэд гэх мэт/ тохиолдлуудад тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан /өртөөний дарга/-ы зөвшөөрлөөр үүссэн хугацааны зогсолтыг чөлөөлж өгч болно.

9 НЭМЭГДЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

9.1. АЧАА ХАДГАЛАМЖИЙН ХУРААМЖ

9.1.1 “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн агуулах, талбайд ачааг хадгалбал ачааны цэвэр жингийн тонн тутмаас доорх тарифын дагуу тооцож авна. Ачаа хадгалалтын хөлсийг тооцохдоо 1 тонн хүрэхгүй жинг 1 тонн болгон бүхэлчлэн тооцно. Үүнд:

а. Ачааг битүү агуулахад хадгалбал хоног тутамд 1500 төгрөг, дээвэртэй саравчинд хадгалбал 1000 төгрөг, задгай талбайд хадгалбал 500 төгрөгөөр тус тус тооцож авна.

б. “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн зам, талбай, зурвас газарт ачаа эзэмшигчийн хүсэлтээр, түүний өөрийн харуул хамгаалалтад ачаа хадгалсан тохиолдолд ачааны 1 тонн тутмаас хоногт 250 төгрөгөөр тус тус тооцно.

в. Дулааны тохируулгатай агуулахад хадгалбал битүү агуулахад хадгалсны тарифыг 150% нэмэгдүүлж тооцно.

9.1.2. Ачаа, чингэлгийг “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн зам, талбайд буулгасан өдрийнхөө дараа өдрийн 00⁰¹ цагаас эхлэн 24 цаг үнэ төлбөргүй хадгална.

9.1.3. Мөн тус журмын 9.1.2-т заасан хугацааг тээврийн гэрээгээр зохицуулж болно.

9.1.4. “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн талбайд тээвэрлэгчид үл харьяалагдах ачаатай чингэлгийг хадгалахад (чингэлэг доторх ачааны хэмжээ хамаарахгүй) хоног тутамд:

20 фут-ээс их 30 фут хүртэлх чингэлэг тутамд 12000 төгрөг,

30 фут ба түүнээс дээш 40 фут хүртэлх чингэлэг тутамд 14000 төгрөг,

40 фут ба түүнээс дээш чингэлэг тутамд 16000 төгрөгөөр тооцож авна.

9.1.5. Хоосон чингэлгийн хадгалалтын тарифыг тооцохдоо тухайн төрлийн ачаатай чингэлгийн тарифыг 50% бууруулж тооцно.

9.1.6. Тээвэрлэгчээс шалтгаалан үйлчлүүлэгчдэд цаг хугацаанд нь ачааг ачилт, буулгалтын үйлчилгээ хийж өгч чадаагүй /байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан салхи шуурга болон ачаа ачиж буулгах техник тоног төхөөрөмж эвдрэл гэмтэлтэй болон тээвэрлэгчийн буруутай байдлаас үүсэн гарсан нөхцөлүүдэд гэх мэт/ тохиолдлуудад тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр үүссэн хугацааны ачаа хадгалалтын хөлснөөс чөлөөлж өгч болно.

9.2 АЧААНЫ БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ, ТОО ХЭМЖЭЭ, ЖИНГ ШАЛГАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖ

9.2.1 Ачааны жинг төмөр замын хүч хэрэгслээр шалгасан тохиолдолд үйлчилгээний төлбөр хураамжийг дараах байдлаар тооцож авна. Үүнд:

- а. Ачааны жинг авто пүүгээр тодорхойлсон бол чингэлэг тутмаас 7500 төгрөг;
- б. Ачааны жинг төмөр замын вагон пүүгээр тодорхойлбол вагоны даацаас үл хамааруулан вагон тутмаас 20000 төгрөг;
- в. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр хоосон тээврийн хэрэгслийн жинг авто пүүгээр тодорхойлсон бол тээврийн хэрэгсэл тутмаас 20000 төгрөг;

9.2.2. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр ачааны шинж байдал, тоо хэмжээ, жинг шалгах, ачааг барааны жин дээр тавих, буулгах зэрэг ажлыг төмөр замын хүч хэрэгслээр гүйцэтгэсэн тохиолдолд ачааны жинг шалгасан хөлснөөс гадна цаг хүрэхгүй хугацааг бүтэн цагт тооцож шалгалтад оролцсон ажилчдын тоогоор ажилласан хүн-цаг тутамд 15000 төгрөгийн төлбөр хураамж авна. Энэхүү заалт нь вагон болон авто пүүнд хамаарахгүй.

9.2.3. Ачаа, вагон, чингэлгийг пүүлсний дараа жин нь падаанд бичигдсэн /үйлчлүүлэгчийн мэдүүлсэн/ жингээс зөрсөн тохиолдолд вагон /чингэлэг/-ы даацаас хэтэрсэн тохиолдолд илүү гарсан ачааг буулгах арга хэмжээ авна. Энэ тохиолдолд дахин ачилт, буулгалт, сэлгээний ажил, вагон лүүлсний төлбөр хураамжийг энэхүү мөрдлөгт заасны дагуу ачаа илгээгч /хүлээн авагч/-ээс тооцож авна. Харин пүүлсний дараа жин нь вагон /чингэлэг/-ы даацаас хэтрээгүй тохиолдолд үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу пүүний жинг үндэслэн тээврийн бичиг баримт /падаан/-ыг үйлдэнэ.

9.3 ИЛГЭЭГЧ АЧААГАА БУЦААЖ АВСНЫ ХУРААМЖ

9.3.1. Анхны илгээх өртөөн дээр ачаа илгээгчийн хүсэлтээр ачааг буцааж өгвөл илгээгчээс ачаа хадгалалтын төлбөр хураамжийг энэхүү мөрдлөгийн 10.1-д заасан хэмжээгээр тооцож авна. Мөн ачилт, буулгалт болон бусад ажил үйлчилгээний төлбөр хураамжийн гарсан зардлыг тооцож авах.

9.3.2. Уг ачааг ачих, буулгах хугацааны вагон ашиглалтын төлбөр хураамжийг тарифын дагуу тооцож авна.

9.4 ТЭЭВРИЙН БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭЛТИЙН БОЛОН БУСАД БАРИМТ МАЯГТ, МАТЕРИАЛЫН ТӨЛБӨР ХУРААМЖ

9.4.1. Тээврийн бичиг баримт бүрдүүлэлтийн болон маягт, материалын төлбөр хураамжийг дараах хэмжээгээр авна. Үүнд:

- а. Тээврийн бичиг баримт бүрдүүлэлтийн багц үнэлгээ 1 вагонд 3000 төгрөг Үүнд: /падаан маягт тасалбарын үнэ, ачаа мэдэгдэл, бичиг баримт хадгалалтын хөлс, ломбоны хөлс г.мэт/ Бүлэг вагонд бүлгээр тээврийн бичиг баримт үйлдэхэд мөн адил вагон тутмаас тооцно.
- б. Ачаа бэхэлсний төлбөр хураамжийг гарсан зардлаар нь тооцно. Ингэхдээ бэхэлгээ хийх ажиллагаанд оролцсон ажилтны хүн-цагийн төлбөр, бэхэлгээнд шаардлагатай материал хэрэгслийн тоо хэмжээ, тухайн ажлын төвөгшил зэргийг тооцсон бодох аргачлалыг боловсруулан баталсан байна.
- в. Ачаа хүргэх хугацаа хэтрээгүй байхад илгээгч /хүлээн авагч/-ийн хүсэлтээр ачааны эрэл хийсэн тохиолдолд илгээлт бүрээс 10000 төгрөг,

9.4.2. “МТЗ” ТӨХК-тай бичиг баримт цахим хэлбэрээр солилцох явцад ачаа илгээгчийн хүсэлтээр тээврийн падаан, захиалгын маягт бөглөхөд хураамжийг дараах хэмжээгээр авна. Үүнд:

- а/ цахим захиалга бүрдүүлэлтийн хураамжийг хуулийн этгээдээс илгээлт тутамд – 15000 төгрөг, хувь хүнээс илгээлт тутамд -5000 төгрөг

9.5 ВАГОН /ЧИНГЭЛЭГ/ ЦЭВЭРЛЭСЭН, АРИУТГАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖ

9.5.1. Төмөр замын эзэмшлийн нийтийн хэрэглээний замд буулгалтаас суларсан вагоныг ачаа хүлээн авагчийн хүч, хэрэгслээр цэвэрлүүлэн хүлээн авна. Вагоныг ачаа хүлээн авагч цэвэрлээгүй тохиолдолд төмөр замын хүч, хэрэгслээр цэвэрлэж 4 голт вагон тутмаас 100000 төгрөг, 4-өөс дээш голт вагон тутамд 150000 төгрөгөөр тус тус бодож хураана.

9.5.2. Ачаа хүлээн авагч нь буулгалтын дараа чингэлгийг цэвэрлээгүй орхисон бол цэвэрлэгээний хөлсийг доорх хэмжээгээр авна. Үүнд:

20 фут-ээс 30 фут чингэлэгт 50000 төгрөг;

30 фут-ээс 40 фут чингэлэгт 66000 төгрөг;

40 фут ба түүнээс дээш чингэлэгт 75000 төгрөг;

9.5.3. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр эсвэл хорио цээрийн дэглэмийн үед вагон /чингэлэг/-ыг зориулалтын зааврын дагуу ариутгасны төлбөр хураамжийг тухайн гарсан зардлаар тооцож авна.

9.6 ҮНЭ ЗАРЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖ

9.6.1. Зарласан үнийн 1000 төгрөг тутмаас 50 төгрөгийн төлбөр хураана.

9.6.2. Импортын ачааны үнийг валютаар зарласан бол энэ төлбөрийг Монгол банкнаас тогтоосон тухайн өдрийн ханшаар хөврүүлэн тооцож, үнэ зарласны төлбөр хураамжийг 9.6.1-д дурдсан байдлаар тодорхойлно.

9.7 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗАХИАЛГАГҮЙ АЧААНЫ ТЭЭВРИЙН ТАРИФ БОДОХ

9.7.1. Тээвэрлэлтийн захиалгын төмөр замаар тээвэрлэх дүрэмд заасны дагуу жилийн захиалгыг улирлаар хуваарилан гаргаж он эхлэхээс 2 сарын өмнө, сарын захиалгыг сар эхлэхээс 10 хоногийн өмнө ирүүлээгүй тохиолдолд ачааг тээвэрлэлтийн захиалгагүй ачаанд тооцно.

Тээвэрлэлтийн захиалгагүй ачааг тээвэрлэхэд тээвэрлэлтийн тарифыг 10% нэмэгдүүлж тооцно.

9.8 БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

9.8.1. Ачааны мэдүүлэг /манифест/ бичсэн үйлчилгээний төлбөр хураамжийг вагон, чингэлэг тутмаас доорх байдлаар тооцон авна.

- Импортын тээвэрт	7000 төгрөг
- Экспортын тээвэрт	5000 төгрөг
- Хавсралт тутмаас	2000 төгрөг

Энэ хураамжийг экспортын тээвэрлэлтээс суларсан дотоодын эзэмшигчийн тээвэрлэгчид үл харьяалагдах болон түрээсэлж авсан хоосон вагонд тооцохгүй.

9.8.2. Хөрш орнуудын төмөр замд экспорт хийх үед ачаа илгээгчийн, импортын тээвэрлэлт хийх үед хүлээн авагчийн хүсэлтээр тус тус хүрэх өртөө, хүлээн авагч, худалдан авагч, гэрээний дугаар солигдвол үйлчлүүлэгчийн хүсэлтээр уг ачааг хүлээн авах тухай цахилгаан мэдээ явуулахад илгээгч буюу хүлээн авагчаас нэг удаагийн цахилгаан мэдээ илгээлтэд 30000 төгрөгийн хураамж авна.

9.8.3. Энэхүү мөрдлөгийн "Нэмэгдэл ажил, үйлчилгээний төлбөр хураамж" бүлэгт тусгагдаагүй бусад үйлчилгээг үзүүлэх тохиолдолд үйлчилгээний тарифыг Санхүү,

төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн тооцоог үндэслэн, “МТЗ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдөнө.

9.8.4. Вагон, чингэлгийн бэхэлгээг тайлсан, тасалсны хураамж – вагон тус бүрээс 5000 төгрөг, хэрэв чингэлэгтэй бол чингэлэг тус бүрээс 2000 төгрөг байна.

10 ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

10.1 ВАГОНЫГ БҮРЭН СУЛЛААГҮЙ, ЦЭВЭРЛЭЭГҮЙГЭЭС ҮҮСЭХ ХАРИУЦЛАГА

10.1.1. Нийтийн болон дагнасан хэрэглээний замд буулгалтаас суларсан вагон /чингэлэг/-ыг ачаа хүлээн авагчийн хүч, хэрэгслээр цэвэрлэнэ. Вагоныг ачааны үлдэгдэл, бусад хог хаягдлаас бүрэн цэвэрлээгүй тохиолдолд хүлээн авахгүй байх эрхтэй бөгөөд буулгалтын санамжийг үргэлжлүүлэн тооцож, тарифын дагуу вагон ашиглалтын төлбөрийг авна.

10.1.2. Бүрэн цэвэрлэгдээгүй эсвэл ачааны үлдэгдлээс бүрэн суллаагүй вагоныг буулгалтын замаас татан авсан тохиолдолд тухайн өртөө хариуцаж вагоныг цэвэрлэж дараагийн ачилтад явуулах асуудлыг хариуцна.

10.2 ТЭЭВРИЙН БОЛОН БУСАД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ ТӨЛӨӨГҮЙГЭЭС ҮҮСЭХ ХАРИУЦЛАГА

10.2.1. Ачаа хүлээн авагч нь өртөөнд ачаа ирсэн тухай мэдэгдэл авсан өдөртөө багтаан тээвэрлэлттэй холбогдох төлбөр тооцоог хийж, тээврийн бичиг баримтыг авна. Харин 17:00 цагаас хойш ирсэн ачааны тээвэртэй холбоотой төлбөр тооцоог дараагийн хоногийн 17:00 цагт багтаан хийсэн байна.

10.2.2. “МТЗ” ТӨХК-иар үйлчлүүлэгч нь төлбөр тооцоог тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд төмөр замаар ачаа тээвэрлэхтэй холбоотой холбогдох гэрээнд заасны дагуу алдангийг тооцно. Тээврийн орлогын бүртгэлд хяналт тавьж тогтоосон хугацаанд орж ирээгүй орлогод нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгж алдангийг тооцож үйлчлүүлэгчид төлбөрийн нэхэмжлэл илгээнэ.

10.2.3. Ачаа илгээгч нь захиалга өгөхдөө ачааны жин, байрны тоо, овор хэмжээ, нэр төрлийг буруу мэдүүлсэн /бичсэн/ тохиолдолд тухайн ачаа тээврийн тарифыг 50 хувь нэмэгдүүлэн тооцож хураана.

11 ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ӨӨРИЙН ГОЛ ДЭЭР ТЭЭВЭРЛЭСНИЙ ХУРААМЖИЙГ БОДОХ

Хөдлөх бүрэлдэхүүн /төмөр замын өргүүрийг оролцуулан/-ийг өөрийн гол дээр нь тээвэрлэсний хураамжийг бодохдоо 1 гол километр /1 гол-км/-ийн тарифыг хөдлөх бүрэлдэхүүний голын тоо болон явах зайгаар үржүүлж тодорхойлно. 1 гол-км-ийн тариф нь дараах үнэлгээтэй байна. Үүнд:

а. Вагоны 1 гол-км-ээс 250 төг;

б. Зүтгүүрийн 1 гол-км-ээс 250 төг

в. Тусгай зориулалтын хөдлөх бүрэлдэхүүний (тогтмол дулаант болон транспортёр вагон, зам засварын техник, зам хэмжигч, жин хэмжүүрийн вагон гэх мэт) 1 гол-км-ээс 300 төгрөгөөр тус тус бодож авна.



12. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХҮСЭЛТИЙН ДАГУУ ҮЗҮҮЛЭХ ТҮРЭЭСИЙН БОЛОН НЭМЭГДЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР БОДОХ

12.1. “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн зүтгүүр, ачааны вагон зэргийг гэрээний үндсэн дээр бусад төмөр замын байгууллага, компани, иргэдэд түрээсээр ашиглуулж болно. Энэ тохиолдолд санхүү, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн тооцоо, судалгааг үндэслэл болгоно.

12.2. Зүтгүүр, вагоныг түрээсээр ашиглуулах тарифыг санхүү, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн тооцоо судалгаанд тулгуурлан тогтооно.

12.3. “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн бус салбар замд байцаагчийн хяналт тавихад зам эзэмшигчээс салбар замын дэлгэмэл уртын километр бүрээс жилд 20000 төгрөгийн төлбөр хураамж авна. Километр хүрэхгүй километр тооцно.

12.4. “МТЗ” ТӨХК-ийн харьяа зурвас газар болох зам, талбай, агуулах, барилга, байгууламжийг түрээслэхдээ “МТЗ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын баталсан журмын дагуу гэрээгээр зохицуулна.

12.5. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр тээврийн бичиг баримтад заасан хаягийг сольсон тохиолдолд вагон тутамд 80000 төгрөг, чингэлэг тутмаас 60000 төгрөг, өртөөн доторх хаяг солилт буюу салбар замын сонголт хийсэн тохиолдолд вагон тутмаас 50000 төгрөг, чингэлэг тутмаас 40000 төгрөгийн хураамж авна.

12.6. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр тээврийн бичиг баримтад засвар хийсэн тохиолдолд илгээлт тус бүрээс 30000 төгрөгийн хураамж авна.

12.7. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр вагон, чингэлгийг бүтээлгээр бүтээх, нэмэлт бэхэлгээ хийх, зэрэг үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд гарсан зардлаар тооцно.

12.8. “МТЗ” ТӨХК-тай тээвэр зуучлалын үйлчилгээний гэрээний дагуу тээвэрлүүлэгчид эзэмшлийн бус суурь бүтцээр “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн вагоныг тээвэрт оролцуулсны хөлсийг “МТЗ” ТӨХК-ийн замаас бусдын эзэмшлийн зам руу орох уулзварын өртөөнөөс галт тэрэг явсан, эргэж ирсэн хугацаагаар галт тэрэгний биечилсэн хуудас (натурк)-ыг үндэслэн вагоны төрлийг харгалзан вагон-хоног тутмаас вагон ашиглуулсны хөлсийг тооцно.

Д/д	Вагоны төрөл	Хэмжих нэгж	Вагон-хоногийн үнэлгээ
1	Тавцант вагон	Вагон-хоног тутмаас	80,000
2	Хагас вагон	Вагон-хоног тутмаас	90,000
3	Битүү вагон	Вагон-хоног тутмаас	92,000
4	Хашлагатай тавцант вагон	Вагон-хоног тутмаас	70,000

ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр

Хүснэгт 1.1 Орон нутгийн вагон илгээлтийн тээврийн тариф

/Вагон.төгрөг/

Бүлгийн дугаар	1		2	3	4	5	6	7	8	9	10	11
Ачааны нэр	Экспортын зориулалттай		Дотоодын эрчим хүчний нүүрс, чулуун нүүрс	Химийн ачаа	Барилгын эдлэхүүн, гөлтгөнө, өнгөт ба хар металл, мод модон материал, модон материалын хаягдал	Төмрийн биш хүдэр /уран/, зэсийн баяжмал, молибден, цайрын баяжмал, жонш, жоншны концентрат, кокс	Төмрийн хүдэр	Нефть, нефтийн бүтээгдэхүүн	Машин механизм, тоног төхөөрөмж	Хүнсний бүтээгдэхүүн	Өргөн хэрэглээний бараа, ноос ноолуур, арьс шир, гэрийн хэрэглэл	Холимог ачаа
	1.1 түүхий нүүрс	1.2 баяжуулсан нүүрс										
1-30	315,900	379,000	252,700	268,500	268,500	379,100	315,900	316,220	221,100	221,100	221,100	315,900
31-40	368,600	442,300	294,900	313,300	313,300	442,300	368,600	334,524	258,000	258,000	258,000	368,600
41-50	473,900	568,700	379,100	402,800	402,800	568,700	473,900	433,980	331,700	331,700	331,700	473,900
51-60	579,200	695,000	463,400	492,300	492,300	695,000	579,200	533,336	405,400	405,400	405,400	579,200
61-70	684,500	821,400	547,600	581,800	581,800	821,400	684,500	632,792	479,200	479,200	479,200	684,500
71-80	789,800	947,800	631,800	671,300	671,300	947,800	789,800	732,248	552,900	552,900	552,900	789,800
81-90	895,100	1,074,100	716,100	760,800	760,800	1,074,100	895,100	831,604	626,600	626,600	626,600	895,100
91-100	1,000,400	1,200,500	800,300	850,300	850,300	1,200,500	1,000,400	931,060	700,300	700,300	700,300	1,000,400
101-110	1,105,700	1,326,800	884,600	939,800	939,800	1,326,800	1,105,700	1,030,416	774,000	774,000	774,000	1,105,700
111-120	1,211,000	1,453,200	968,800	1,029,400	1,029,400	1,453,200	1,211,000	1,129,872	847,700	847,700	847,700	1,211,000
121-130	1,316,300	1,579,600	1,053,000	1,118,900	1,118,900	1,579,600	1,316,300	1,229,328	921,400	921,400	921,400	1,316,300
131-140	1,421,600	1,705,900	1,137,300	1,208,400	1,208,400	1,705,900	1,421,600	1,328,684	995,100	995,100	995,100	1,421,600
141-150	1,526,900	1,832,300	1,221,500	1,297,900	1,297,900	1,832,300	1,526,900	1,428,140	1,068,800	1,068,800	1,068,800	1,526,900
151-160	1,632,200	1,958,600	1,305,800	1,387,400	1,387,400	1,958,600	1,632,200	1,527,496	1,142,500	1,142,500	1,142,500	1,632,200
161-170	1,737,500	2,085,000	1,390,000	1,476,900	1,476,900	2,085,000	1,737,500	1,626,952	1,216,300	1,216,300	1,216,300	1,737,500
171-180	1,842,800	2,211,400	1,474,200	1,566,400	1,566,400	2,211,400	1,842,800	1,726,408	1,290,000	1,290,000	1,290,000	1,842,800
181-190	1,948,100	2,337,700	1,558,500	1,655,900	1,655,900	2,337,700	1,948,100	1,825,764	1,363,700	1,363,700	1,363,700	1,948,100
191-200	2,053,400	2,464,100	1,642,700	1,745,400	1,745,400	2,464,100	2,053,400	1,925,220	1,437,400	1,437,400	1,437,400	2,053,400
201-210	2,158,700	2,590,400	1,727,000	1,834,900	1,834,900	2,590,400	2,158,700	2,024,576	1,511,100	1,511,100	1,511,100	2,158,700
211-220	2,264,000	2,716,800	1,811,200	1,924,400	1,924,400	2,716,800	2,264,000	2,124,032	1,584,800	1,584,800	1,584,800	2,264,000
221-230	2,369,300	2,843,200	1,895,400	2,013,900	2,013,900	2,843,200	2,369,300	2,223,488	1,658,500	1,658,500	1,658,500	2,369,300
231-240	2,474,600	2,969,500	1,979,700	2,103,400	2,103,400	2,969,500	2,474,600	2,316,844	1,732,200	1,732,200	1,732,200	2,474,600
241-250	2,579,900	3,095,900	2,063,900	2,192,900	2,192,900	3,095,900	2,579,900	2,422,300	1,805,900	1,805,900	1,805,900	2,579,900

01.222.031
0214203 017
01.222.031
0214203 017

Хүснэгт 1.2 Орон нутгийн тээврийн чингэлэг илгээлтийн тээврийн тариф


/Чингэлэг.төгрөг/

Бүлгийн дугаар	12						
Ангилал	Ачаатай				Хоосон		
Чингэлгийн төрөл	20 футээс дээш 30 фут хүртэл	30 футээс дээш 40 фут хүртэл	дээвэргүй чингэлэг /20 фут/		20 футээс дээш 30 фут хүртэл	30 футээс дээш 40 фут хүртэл	дээвэргүй чингэлэг /20 фут/
			Экспортын зориулалттай				
Зай, км			Эрчим хүчний нүүрс, бусад нэр төрлийн ачаа	Бусад нүүрс /Коксжих, баяжуулсан г.м/			
1-30	66,900	89,200	89,200	155,020	38,525	51,290	51,865
31-40	93,900	125,200	125,200	180,780	54,050	71,990	55,085
41-50	120,600	160,800	160,800	232,530	69,345	92,460	58,305
51-60	147,600	196,800	196,800	284,165	84,870	113,160	61,525
61-70	174,300	232,400	232,400	335,800	100,280	133,630	64,745
71-80	201,000	268,000	268,000	387,550	115,575	154,100	67,965
81-90	228,000	304,000	304,000	439,185	131,100	174,800	71,185
91-100	254,700	339,600	339,600	490,820	146,510	195,270	74,405
101-110	281,400	375,200	375,200	542,455	161,805	215,740	77,625
111-120	308,400	411,200	411,200	594,205	177,330	236,440	80,845
121-130	335,100	446,800	446,800	645,840	192,740	256,910	84,065
131-140	361,800	482,400	482,400	697,475	208,035	277,380	87,285
141-150	388,800	518,400	518,400	749,225	223,560	298,080	90,505
151-160	415,500	554,000	554,000	800,860	238,970	318,550	93,725
161-170	442,500	590,000	590,000	852,495	254,495	339,250	96,945
171-180	469,200	625,600	625,600	904,130	269,790	359,720	100,165
181-190	495,900	661,200	661,200	955,880	285,200	380,190	103,385
191-200	522,900	697,200	697,200	1,007,515	300,725	400,890	106,605
201-210	549,600	732,800	732,800	1,059,150	316,020	421,360	109,825
211-220	576,300	768,400	768,400	1,110,900	331,430	441,830	113,045
221-230	603,300	804,400	804,400	1,162,535	346,955	462,530	116,265
231-240	630,000	840,000	840,000	1,214,170	362,250	483,000	119,485
241-250	656,700	875,600	875,600	1,265,805	377,660	503,470	122,705

Хүснэгт 1.3 Ачааны бүлгийн нэршлийн дэлгэрэнгүй

Бүлгийн дугаар	Ачааны нэр		Ачааны нэр /дэлгэрэнгүй/
1	Экспортын зориулалттай	1.1 түүхий нүүрс	Чулуун нүүрс (Битумт)-Тарчиг, сул бөсөх нүүрс, Дэгдэмхий бодис багатай, коксжих нүүрс, Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс, Тослог нүүрс, 1/3 коксжих нүүрс, хийн тослог нүүрс, Дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрс, Дэгдэмхий бодис их хийн нүүрс, 1/2 барьцалдах нүүрс, Битумт, үл барьцалдах нүүрс
		1.2 баяжуулсан нүүрс	Баяжуулсан антрацит, баяжуулсан чулуун нүүрс, Коксжих нүүрс, сул коксжих нүүрс, хагас дутуу коксжих нүүрс, дунд зэрэг үнслэгтэй, хагас хатуу коксжих нүүрс, өндөр үнслэгтэй, сул коксжих нүүрс, коксжих чанаргүй нүүрс, доод зэргийн коксжих чанаргүй нүүрс
2	Дотоодын эрчим хүчний нүүрс		Сул барьцалдах нүүрс, үл барьцалдах нүүрс, урт дөлт нүүрс, хүрэн нүүрс
3	Химийн ачаа		Химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, бүх төрлийн аюултай ачаа, эм бордоо, радио электроникийн нарийн тоног төхөөрөмж, кабель аппарат, үнэт эдлэл, эрдэнэс, цахилгааны нарийн хэрэгсэл
4	Барилгын эдлэхүүн		Цемент, асфальт тусгайлан тээвэрлэх өнгөлөх материал, тоосго, шохой, элс, чулуу, шавар/ Өнгөт ба хар металл/ Өнгөт ба хар металл тэдгээрийн хайлш түүгээр хийсэн бүтээгдэхүүн, кабель төрөл бүрийн бүрээстэй утас, хаягдал өнгөт ба металл, арматур, ган/ Мод модон материал, модон материалын хаягдал
5	Төмрийн биш хүдэр /уран/ зэсийн баяжмал, молибден, цайрын баяжмал, жонш жоншны концентрат, кокс		Төмрийн биш хүдэр /уран/зэсийн баяжмал, молибден, цайрын баяжмал, жонш жоншны концентрат, кокс
6	Төмрийн хүдэр		Төмрийн хүдэр
4.2 7	Нефть, нефтийн бүтээгдэхүүн		Бензин керосин, мазут, тослох масло, дизель түлш, битум
8	Машин механизм, тоног төхөөрөмж		Автомашин, унадаг дугуй, мотоцикл зэрэг тээврийн хэрэгсэл, ХАА-н механизм тэдгээрийн задлаагүй бие эд анги зүйлс/
9	Хүнсний бүтээгдэхүүн		Хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүн, хурдан гэмтэх муудах хоолны зүйлс, амьтны ба ургамлын тос, тамхины зүйлс, саван, чүдэнз, багсармал тэжээл, амьд адгуус, идэшний ногоо, гурил, хивэг, үр тариа, буудай
10	Ноос ноолуур, арьс шир, гэрийн хэрэглэл		Боловсруулсан болон боловсруулаагүй арьс шир ангийн үс, ноос ноолуур, хялгас, гахайн хялгас, нэхмэл сүлжмэл даавуу, хувцас, цаасан бүтээгдэхүүн, тоглоом, биеийн тамирын эд зүйлс, хөгжим Гэрийн хэрэглэл /Гэрийн хэрэгсэл, хэрэгцээгүй эдлэл, өвс сүрэл ба хамаасан ургамал мод бут суулгац байнгын эргэлтийн сав, баглаа боодол
11	Холимог ачаа		Холимог ачааг нэг вагонд тээвэрлэх
12	Чингэлэг илгээлт		Бүх төрлийн ачааг чингэлгээр тээвэрлэх үед

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
А/217- дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



СУУРЬ БҮТЭЦ АШИГЛУУЛАХ ТАРИФ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монголын төмөр зам ТӨХК /цаашид “МТЗ” ТӨХК гэх/-ийн суурь бүтэц ашиглуулах тарифыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 тоот тушаалын есдүгээр хавсралт “Суурь бүтэц ашиглуулах журам”, аравдугаар хавсралт “Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлал”-уудыг үндэслэн ашиглалтын дундаж өртөгт суурилсан зардлыг тооцож, компанийн “Стратеги төлөвлөгөө-2050” баримт бичгээс холбогдох мэдээлэл, тооцоог авч ашигласан болно.

2. ТАРИФЫГ ХЭРЭГЛЭХ АРГАЧЛАЛ

2.1. Суурь бүтэц эзэмшигч буюу “МТЗ” ТӨХК нь тээвэрлэгч нартай Монгол Улс нэгдэн орсон Олон улсын гэрээ, Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актууд болон энэхүү журмыг баримтлан суурь бүтэц ашиглуулах гэрээ байгуулж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

2.2. Суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэгчтэй гэрээг бичгээр байгуулах бөгөөд хувийг Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд суурь бүтцийн хүчин чадал хүрэхгүй тохиолдолд тээвэрлэгчийн ирүүлсэн захиалгын хэмжээг зөвшилцөх эсвэл татгалзаж болно. Энэ харилцааг гүйцэтгэхдээ Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Ачаа тээвэрлэлтийн журам”-аар зохицуулна.

2.4. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн суурь бүтцийг ашиглан бусдын эзэмшлийн зүтгүүр, вагоноор тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэх тохиолдолд тус тушаалын гуравдугаар хавсралтын 4.3 дугаар хэсэгт заасан суурь бүтэц ашиглуулах тарифыг мөрдөнө.

3. СУУРЬ БҮТЭЦ АШИГЛУУЛАХ ТАРИФЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

3.1. Тавантолгой – Гашуунсухайт, Тавантолгой – Цогтцэций чиглэлийн төмөр замаар суурь бүтэц ашиглуулсны хөлсийг дараах аргаар тооцно.

$$T = (a \cdot b \cdot l)$$

a – суурь бүтэц ашиглалтын 1 тн.км-ийн тогтоосон тариф, төг/тн.км

b – тээвэрлэлтийн зай, км

l - захиалсан галт тэрэгний цэвэр жин /чингэлэг илгээлт бол чингэлгийн хувийн жин/, тонныг оруулан тооцно.

4. “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН МӨРДӨН АЖИЛЛАХ СУУРЬ БҮТЭЦ АШИГЛУУЛАХ ТАРИФ

4.1. Тавантолгой өртөөнөөс Гашуунсухайт өртөө чиглэлийн төмөр замын суурь бүтэц ашиглуулах тариф 1 тн-км-т ногдох 84.2 төгрөг байна.

4.2. Тавантолгой өртөөнөөс Цогтцэций өртөө чиглэлийн төмөр замын суурь бүтэц ашиглуулах 1 тн-км-т ногдох тариф 65.5 төгрөг байна.

4.3. Хоосон тээвэрлэлтийн хөлсийг хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн гол дээр тээвэрлэх 1 гол километрийн тарифаар тооцно. Хөдлөх бүрэлдэхүүнийг өөрийн гол дээр

нь тээвэрлэсний хураамжийг бодохдоо 1 гол километр /1 гол-км/-ийн тарифыг хөдлөх бүрэлдэхүүний голын тоо болон явах зайгаар үржүүлж тодорхойлно. 1 гол. км-ийн тариф нь дараах үнэлгээтэй байна. Үүнд:

- а. Вагоны 1 гол.км-ээс 250 төг;
- б. Зүтгүүрийн 1 гол.км-ээс 250 төг.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
1/27 дугаар тушаалын Гуравдугаар хавсралт



Тавантолгой - Гашуунсухайт чиглэлд “Экспортын нүүрсийг төмөр замаар тээвэрлэх

1 тонн ачааны багцын тариф”

Хүснэгт 3.1 Багцын тариф / НӨАТ-тай дүн, төгрөг/


№	Ачих цэг	Буулгах цэг	1 бүтэн эргэлтийн багц үнэ /1тн ачаа/
1	“Түр ачилтын терминал”, “Тавантолгой өртөөний ачилт буулгалтын 8-р зам”	Гашуунсухайт өртөө-Шилжүүлэн ачих терминал	49,412.00
2	“Түүхий нүүрс ачилтын логистикийн төв”, “Ачилтын тойрог-2” салбар зам, бусад хувийн эзэмшлийн салбар зам	Гашуунсухайт өртөө-Шилжүүлэн ачих терминал	45,860.84

Тайлбар:

1. Экспортын нүүрсийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд багцын тарифаар тээвэрлүүлэхээр Тээвэрлүүлэгчтэй гэрээ байгуулсан тохиолдолд дээрх тарифыг хэрэглэнэ.
2. Багцын тарифт эрчим хүчний нүүрс ороогүй болно.
3. Багцын тариф нь ачаатай болон хоосон талын 1 бүтэн эргэлтэнд хамаарна.
4. Хувийн эзэмшлийн салбар зам гэдэгт тухайн байгууллага өөрийн хүч хэрэгслээр талбайн үйлчилгээ, ачилт буулгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
5. Ачааны хэмжээ бутархай тохиолдолд дэвшүүлэн бүхэл утгаар тооцно. (66.4 тн = 65 тн)
6. Тээвэрлүүлэгчээс шалтгаалсан (тээвэрлэлтийн шаардлага хангаагүй, тээвэрт шаардлагатай тооны чингэлэг бэлдээгүй гэх мэт) дахин сэлгээ хийх, салбар замд вагон тавьж өгөх, татаж авах зэрэг ажлууд хийгдсэн тохиолдолд гарсан зардлыг 1 дүгээр хавсралтаар батлагдсан тарифын дагуу тооцож тээвэрлэгчдэд төлнө.

---oOo---

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
А/27 дугаар тушаалын Дөрөвдүгээр хавсралт



ТАРИФЫН 2-Р МӨРДЛӨГ

Энэхүү мөрдлөг нь “МТЗ” ТӨХК-ийн өртөө, зөрлөгийн байрлалын километр, тэдгээрийн гүйцэтгэх ажиллагаа, тээвэрлэлтийн зайн хүснэгтээс бүрдэнэ.

1. “МТЗ” ТӨХК-ийн өртөө зөрлөгт гүйцэтгэх ажиллагааг томьёолсон тэмдэг

Томьёолсон тэмдэг	Гүйцэтгэх ажиллагаа
1	Вагон илгээлт хүлээн авах, олгох
1.1	Орон нутгийн харилцааны вагон илгээлт хүлээн авах, олгох
1.2	Олон улсын харилцааны вагон илгээлт хүлээн авах олгох
2	Их даацын чингэлэг хүлээн авах олгох
2.1	Орон нутгийн харилцааны их даацын чингэлэг хүлээн авах, олгох
2.2	Олон улсын харилцааны их даацын чингэлэг хүлээн авах, олгох
3	Дамжуулах галт тэрэг

2. “МТЗ” ТӨХК-ийн өртөө, зөрлөгийн кодчиллол ба гүйцэтгэх ажиллагаа

Өртөөний код	Өртөө, зөрлөгийн нэр	Гүйцэтгэх ажиллагаа	Өртөө, зөрлөг байрлаж буй километр
	Эхлэл цэг		0.0
31 020099	Хулангийншанд зөрлөг	3	77
31 020081	Цагаанцав зөрлөг	3	-
31 020073	Борхошуу зөрлөг		144
31 020065	Хунхарзаг зөрлөг		195
31 020058	Баянбулаг зөрлөг		227
31 020040	Архонгилдог зөрлөг		287
31 020032	Хонгортолгой зөрлөг		357
31 020024	Цогтцэций өртөө	1, 2, 3	415
31 032014	Тавантолгой өртөө	1,2	0.0
31 030026	Хайрхан зөрлөг		20
31 030034	Хангай зөрлөг		61
31 030042	Урт гол зөрлөг		100
31 030059	Оюут зөрлөг		144
31 030067	Шинэ-Ус зөрлөг		171
31 030075	Хулант зөрлөг		214
31 031081	Гашуунсухайт өртөө	1,2	226

3. "МТЗ" ТӨХК-ийн хооронд өртөө, зөрлөгийн хоорондын зай

Д/д	Өртөө, зөрлөгийн нэрс	Өртөө, зөрлөг хоорондын зай /км/	Өртөө, зөрлөгийн нэрс ба тайлбар
1	Эхлэл цэг (0 км)	77	Хулангийншанд зөрлөг
2	Хулангийншанд зөрлөг	35	Цагаанцав зөрлөг
3	Цагаанцав зөрлөг	32	Борхошуу зөрлөг
4	Борхошуу зөрлөг	51	Хунхарзаг зөрлөг
5	Хунхарзаг зөрлөг	32	Баянбулаг зөрлөг
6	Баянбулаг зөрлөг	60	Архонгилдог зөрлөг
7	Архонгилдог зөрлөг	70	Хонгортолгой зөрлөг
8	Хонгортолгой зөрлөг	58	Цогтцэций өртөө
9	Цогтцэций өртөө	22	Тавантолгой өртөө
10	Тавантолгой өртөө	20	1-р зөрлөг /Хайрхан/
11	1-р зөрлөг /Хайрхан/	41	2-р зөрлөг /Хангай/
12	2-р зөрлөг /Хангай/	39	3-р зөрлөг /Урт гол/
13	3-р зөрлөг /Урт гол/	44	4-р зөрлөг /Оюут/
14	4-р зөрлөг /Оюут/	27	5-р зөрлөг /Шинэ-Ус/
15	5-р зөрлөг /Шинэ-Ус/	43	6-р зөрлөг /Хулант/
16	6-р зөрлөг /Хулант/	12	Гашуунсухайт өртөө
ТТӨ-ГСӨ хүртэл шугамын урт		226	Хил холбогдох хүртэл тарифын зай
17	Гашуунсухайт өртөө	8	Улсын урд хил
ТТӨ-Хил шугамын урт /км/		234	Хил холбогдсоны дараах тарифын зай

---oOo---

